



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Хувьчлалын жагсаалтаас хасах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн өмчөөс 2015-2020 онуудад хувьчлахаар баталсан хавсралтад дурдсан хуулийн этгээд, барилга байгууламжуудыг хувьчлалын жагсаалтаас хассугай.

2.Хувьчлалын жагсаалтаас хасагдаж буй барилга байгууламжуудын эзэмшил, ашиглалтад хяналт тавих ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1116100386

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 12 дугаар тогтоолын хавсралт

ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН ЖАГСААЛТААС ХАСАХ ХУУЛИЙН ЭТГЭЭД, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

№	Хуулийн этгээд, эд хөрөнгийн нэр	Хувьчлах талаар гарсан шийдвэрүүд	Жагсаалтаас хасах үндэслэл	Тайлбар
1	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хуучин барилга	НИТХ-ын 2015 оны 24/05 дугаар тогтоол	5 удаа нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахаар зарласан боловч санал ирээгүй.	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газраас тус барилгыг буулгаж ногоон байгууламж бүхий нийтийн эзэмшлийн талбай болгох хүсэлтэй байгаа тул хувьчлалын жагсаалтаас хасуулах хүсэлт ирүүлсэн.
2	Хар үнэгний аж ахуйн барилга байгууламж	НИТХ-ын 2020 оны 02/13 дугаар тогтоол	7 удаа нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахаар зарласан боловч нэг ч санал ирээгүй.	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас нохой, муурын байр болгохоор засаж байна.
3	Сүхбаатар дүүргийн 15 дугаар хорооны халуун усны барилга	НИТХТ-ийн 2020 оны 02/13 дугаар тогтоол	Сүхбаатар дүүргийн 15 дугаар хорооны иргэдэд үйлчилгээ үзүүлэх	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас хувьчлалын жагсаалтаас хасуулах хүсэлт ирүүлсэн.
4	Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны халуун усны барилга	НИТХТ-ийн 2020 оны 02/13 дугаар тогтоол	Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны иргэдэд үйлчилгээ үзүүлэх	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас хувьчлалын жагсаалтаас хасуулах хүсэлт ирүүлсэн.
5	Сүхбаатар дүүргийн 18 дугаар хорооны халуун усны барилга	НИТХТ-ийн 2020 оны 02/13 дугаар тогтоол	Сүхбаатар дүүргийн 18 дугаар хорооны иргэдэд үйлчилгээ үзүүлэх	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас хувьчлалын жагсаалтаас хасуулах хүсэлт ирүүлсэн.
6	"Чандмань Налайх" ОНӨААТҮГ-ын Ахуй үйлчилгээний төв	НИТХ-ын 2018 оны 20/21 дүгээр тогтоол	Сонгон шалгаруулалтыг нийтэд зарласан боловч оролцох этгээдийн санал ирээгүй болно.	"Чандмань Налайх" ОНӨААТҮГ нь өөрийн хөрөнгөөр их засвар хийж Ахуй үйлчилгээний төвийн зориулалтаар үйл ажиллагаа явуулж байгаа тул хувьчлалын жагсаалтаас хасах санал ирүүлсэн
7	Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны хуучин барилга	НИТХ-ын 2017 оны 02/24 дүгээр тогтоол	Сүхбаатар дүүргийн ЖДҮДТ-ийн харьяа "Сүхбаатарт үйлдвэрлэв" худалдааны цэг байрладаг.	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас хувьчлалын жагсаалтаас хасуулах хүсэлт ирүүлсэн.

8	Сүхбаатар дүүргийн 18-р хороо, Цагдаагийн 2-р хэлтсийн хуучин барилга	НИТХ-ын 2015 оны 32/29 дүгээр тогтоол	Нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулж явуулахаар нийтэд зарласан боловч санал ирээгүй.	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас хувьчлалын жагсаалтаас хасуулах хүсэлт ирүүлсэн.
9	Хан-Уул дүүргийн 16 дугаар хорооны халуун усны барилга	НИТХТ-ийн 2020 оны 02/13 дугаар тогтоол	Хан-Уул дүүргийн Цагдаагийн газрын харьяа камерын хяналтын нэгдсэн төв болгохоор уг байрыг бүрэн засварлаж байна.	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газраас хувьчлалын жагсаалтаас хасуулах хүсэлт ирүүлсэн.

